



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/180

Бор-Өндөр сум

Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2, дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны А/115 дугаар тушаал, Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны А/43 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны А/435 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Р.Цэндсүрэн

Нарийн бичгийн дарга

Э.Гуамарал

Гишүүд

Б.Мөнх-Оргил

Н.Отгонбилэг

Ц.Бат-Эрдэнэ

Ц.Төртүвшин

Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч

Хүйх 5-р багийн Зохион байгуулагч

Хүйх 5-р багийн Засаг дарга

Өлгий 6-р багийн Засаг дарга

Ноён Зүлэгт ХХК МЭҮН-ийн захирал

ЭнТэЧи ХХК МЭҮН-ийн захирал

2. Зооноз, архаг халдварт малын Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2025 оны нийт охин төл малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ний өдрөөс эхлүүлсүгэй.

3. Дархлаажуулалтад хамрагдах төл малын хуваарийг хавсралтаар баталсугай.

4. Малчин, мал бүхий иргэдийг татан оролцуулах, зарлан мэдээлж, багийн түвшинд хамтран ажиллахыг Хүйх, Өлгий багийн Засаг дарга нар (Н.Отгонбилэг, Б.Мөнх-Оргил)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Жаргалсайхан)-д, гүйцэтгэлийг вакцинжуулалт дууссанаас хойш 7 хоногийн дотор танилцуулж, тарилгын материалыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Р.Цэндсүрэн)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ГАЛБАДРАХ

D:/bichig hereg/Захирамж.docx

Бор-Өндөр сумын Засаг даргын
 2025 оны 07 дугаар сарын 28-ны
 өдрийн /.../ Захирамжийн хавсралт

БОР-ӨНДӨР СУМЫН БРУЦЕЛЛЭЗ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	МЭҮН-ийн нэр	Дархлаажуулалтад хамруулах мал /толгой/						Шаардагдах вакцины хэмжээ						Шингэлэгч /литр/
		Тугал	Хурга	Ишиг	Бод	Бог	Бүгд	br.Abortus-19 омог		Br.Melltensis Rev-1				
								100 тун /ширхэг/	Нийт тун	500 тун	400 тун	300 тун	Нийт тун	
1	ЭНТЭЧИ	200	1569	2431	200	4000	4200	2	200	8			4000	4.40
2	Ноён зүлэгт	200	2120	2380	200	4500	4700	2	200	9			4500	4.90
Бүгд		400	3689	4811	400	8500	8900	4	400	17	0	0	8500	9.30

ТАРХВАР ЗҮЙЧ
 ХУВААРЬ ГАРГАСАН
 Р.ЦЭНДСҮРЭН